



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 он

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
2022-2025 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг хянасан:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

Төсвийн Ерөнхийлөн захирагч

/...../

(огноо)

Тэмдэг

.....

Төлөвлөгөө баталсан:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

Төсвийн Шууд захирагч

/...../

(огноо)

Тэмдэг

.....

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Зоонозын өвчний эрсдэл дэлхий дахинд: Зоонозын өвчин нь сөрөг үр нөлөө, хохирлоороо нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэдэг, хариу арга хэмжээ нь олон салбарын оролцоотой хэрэгждэг нас баралт өндөр /30-100 хувь/ өвөрмөц бүлэг өвчин юм. Дэлхийн дулаарал, даяаршил, аялал жуулчлалын эрчимтэй хөгжил, цаг уурын өөрчлөлт нь Зоонозын буюу шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний дэгдэлт, эрсдэлийг эрс ихэсгэж дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Томуугийн болон Ковид19-ын цар цахал, эбола, зика вирус, тарваган тахлын халдварууд тасралтгүй гарч хүн амын эрүүл мэнд, улс орнуудын эдийн засагт асар их хохирол учруулж байна. Зоонозын халдварт өвчин нь хүн амын дунд маш өндөр хурдацтай тархдаг онцлогтой бөгөөд шинэ ба сэргэн тархах халдваруудын 75 хувийг зоонозын өвчин эзэлж байна. Нийт халдварт өвчний 60 хувийг зоонозын гаралтай халдварт өвчин эзлэж байгаа бөгөөд шинээр бүртгэгдэж байгаа 5 шинэ өвчин дутмын 3 нь зоонозын гаралтай халдвар байна. Нийт зоонозын өвчний 5 хувь нь зэрлэг амьтдын дунд, 35% нь хүн амд, 60% гэрийн тэжээвэр мал, амьтдын дунд тархсан байдаг байна. Жил бүр 2.5 тэрбум хүн зоонозын өвчний эрсдэлд өртөж 2.7 сая хүн зоонозын гаралтай өвчний улмаас нас барж байна. Түүнчлэн зоонозын өвчний 80 орчим хувийг биотерроризмд ашиглах боломжтой гэж судлаачид үздэг байна.

Зоонозын өвчний эрсдэл Монгол улсад: Дэлхий дээр 200 гаруй ерөнхий нэршлийн зоонозын халдварт өвчин бүртгэгдсэнээс Монгол улсад 30 гаруй зоонозын өвчнийг оношилон бүртгэж үүнээс 10 гаруй өвчин нь жил бүр тохиолдож байна. Монгол улсад Зоонозын халдварт өвчний байгалийн голомт Боом 18 аймгийн 157 суманд, Тарваган тахал 17 аймгийн 137 суманд, Галзуу 21 аймгийн 183 суманд тус тус бүртгэгдээд байгаа ба сүүлийн 10 жил хачгаар дамжих халдварт өвчин нийт 6,336 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 33.1% (2,096) нь батлагдаж, 0.9% (18) нь нас барсан байна.

Монгол улсад жилд дундажаар 26000 мал, амьтан өвчилж, 470 орчим хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдэж байгааг статистик мэдээлэл, бичиглэл судалгааны дүн харуулж байгаа бөгөөд 2022 оны статистикаар зоонозын халдварт өвчний сэжигтэй тохиолдлын тоо өмнөх 10 жилийн дунджаас 8 дахин өссөн байна.

2017-2021 онд ОХУ-ын хил дагуу хийсэн хамтарсан судалгаагаар тарваган тахлын цэвэр өсгөвөр жилд 30-44, эерэг сорьц 160-280-ийг тус тус илрүүлсэн. Өмнөд хөрштэй хиллэж буй бүс нутаг, Хавиргын боомт орчим 2017 онд хийсэн тандалт судалгаагаар мэрэгч, туулай хэлбэртний дунд тарваган тахлын эсрэг бие, 2018 онд боррелиоз, риккетсиоз өвчний халдвар, 2019 онд листери өвчний үүсгэгч илрээд байна. Замын-Үүд суманд хийсэн тандалт судалгаагаар нийт 36 мэрэгч амьтанд тарваган тахал 57.9%, хам тохиолдох зоонозын өвчний 10.5 хувийн халдваржилттай нь тогтоогдоод байна. Түүнчлэн хархны нягтшил өндөр байгаа нь цаашид тарваган тахал болон зоонозын бусад өвчин хүнд халдварлаж, дэгдэлт гарах маш өндөр эрсдэлтэй байна. Мөн денгийн халуурал, хумхаа, холер зэрэг дамжуулагчаар дамжих халдварт өвчний тохиолдол зөөвөрлөгдөн бүртгэгдсээр байна.

Монгол улсад Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх бодлого, тогтолцоо: Өнөөдрийн байдлаар Зоонозын өвчин судлалын Үндэсний төв 103

орон тоотой, харьяа 15 Зоонозын өвчин судлалын төвүүдэд 282 нийт 385 гаруй эмч, мэргэжилтэн Монгол улсад зоонозын халдвар тархах хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, зоонозын өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж байна.

Дэлхий дахинд Зоонозын болон шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчний дэгдэлт, эрсдэл эрс нэмэгдэж, Ковид19 –ын цар тахал дэгдэж буй энэ цаг үед Монгол улс дэлхийн бусад улс орнуудын адил томоохон сорилттой нүүр тулж байгаа бөгөөд цаашид болзошгүй цар тахал, зоонозын өвчинтэй тэмцэх сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, хариу арга хэмжээ, нөөцийн бэлэн байдлаа эрс сайжруулах асуудал нийгмийн эрүүл мэндийн гол тулгамдсан асуудал болоод байгаа билээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын бодлого төлөвлөгөөнд: “Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль”-ийг яаралтай батлан хэрэгжүүлэх, “Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлэх” /1.1.2.4./, “Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулах”, /1.1.3.2/, “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулах”, /1.1.3.4./ зэрэг бодлогын чухал заалтууд тусгагдан хэрэгжүүлж эхэлж байна.

Зоонозын Өвчин судлалын Үндэсний төвийн 2017-2021 оны дунд хугацааны Стратегийн төлөвлөгөө хэрэгжиж дууссан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувь байсан ба нэгдсэн үнэлгээний дүн гарч, цаашид анхаарах асуудлаа тодорхойлоод байна.

Иймд Зоонозын өвчний дэлхий дахинд болон Монгол улсад учруулж буй эрсдэл нэмэгдсээр байгаа өнөөгийн нөхцөлд Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх тогтолцоог шинэчлэх, сайжруулах Монгол улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамны бодлогын шийдвэр гарч байгаатай болон Төвийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөө хэрэгжиж дууссантай уялдуулан 2022-2025 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагаар энэхүү төлөвлөгөөг боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатыг тодорхойлохдоо чиг үүргийн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн салбарт хамаатай нийт 109 хуулиас Зоонозын салбарт шууд хамаарах 10 хууль, нийтлэг хамаарах 17 хуулинд дараах дөрвөн алхамын хүрээнд шинжилгээг хийсэн. Үүнд:

1. Хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг тодорхойлох
2. Тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилах
3. Салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох
4. Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох зэрэг ажлууд орсон.

Мандатын шинжилгээний үр дүнд ерөнхий чиг үүрэг **3** үндсэн чиг үүрэг **5** дэд чиг үүрэг **17**- г тодорхойлож, доорх хүснэгтээр үр дүнг нэгтгэв.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		26
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	- Эрүүл мэндийн тухай хууль - Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль - Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - Эрүүл ахуйн тухай хууль - Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль - Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль - Мэргэжлийн хяналтын тухай хууль - Гамшигаас хамгаалах тухай хууль
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	- ХДХВ/ДОХ-той тэмцэх сэргийлэх хууль - Дархлаажуулалтын тухай хууль - Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль - Тамхины хяналтын тухай хууль - Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль - Цагдаагийн албаны тухай хууль - Нийгмийн халамжийн тухай хууль - Ахмад настны тухай хууль - Эрүүгийн тухай хууль - Зөрчлийн тухай - Статистикийн тухай хууль - Гаалийн тухай хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Онцгой албан татварын тухай хууль - Иргэний хууль - Эрүүгийн хууль - Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль

		- Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль - Мансууруулах эм сэтгэц нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль - Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай Хөдөлмөрийн хууль - Төрийн албаны тухай хууль - Байгууллагын нууцын тухай хууль - Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль - Төсвийн тухай хууль
Ерөнхий чиг үүрэг-1: - Зоонозын халдварт өвчний хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Монгол Улсын хэмжээнд Зоонозын халдварт өвчнийг тандах, судлах, хянах,	1.1 Төвийн хууль эрх зүйн орчнийг боловсронгуй болгох, 1.2 Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, 1.3 Зоонозын халдварт өвчний хүн амын дундах тархалтыг тогтоох тандалт, судалгаа хийх эрсдлийн түвшинг тогтоох, 1.4 Зоонозын өвчин үүсгэгч бичил биетний өсгөвөр, омог (нян, вирус, эгэл биетэн)-г оношлох, онош баталгаажуулах, 1.5 Зоонозын өвчин үүсгэгч бичил биетэн, (эсрэгтөрөгч, эсрэгбие)-ыг оношлох, оношлуур үйлдвэрлэх Био үйлдвэрлэлийг хөгжүүлэх, 1.6 Зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжлийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх;	Эрүүл мэндийн яам /ЭМЯ/ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ДЭМБ Хүнс, хөдөө аж ахуйн яам, /ХХААЯ/ НЭМҮТ, ХӨСҮТ, Мал эмнэлгийн хүрээлэн /МЭХ/ Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар /ЭМГ/ Мал эмнэлгийн ерөнхий газар /МЭЕГ/ Экологийн хүрээлэн, /ЭХ/ Нийгмийн эрүүл мэндийн төвүүд /НЭМТ/
ҮЧҮ-2: Үндэсний хэмжээнд зоонозын өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих	2.1 Хүн амыг зоонозын халдварт өртөх, өвчлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах, 2.2 Хүн амын дунд зоонозын өвчнөөс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн ажлыг зохион байгуулах:	ЭМЯ, ДЭМБ ХХААЯ НЭМҮТ, ХӨСҮТ, /МЭХ/ Аймаг нийслэлийн ЭМГ Төрийн болон төрийн бус байгууллага
Ерөнхий чиг үүрэг-2: Зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн зоонозын салбарын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах үйл ажиллагаа.		

ҮЧҮ-3: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	3.1 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн бэлэн байдлыг хангах 3.2 Зоонозын өвчний аюул, эрсдлийн үед авах салбар дундын хариу арга хэмжээний багийн бэлэн байдал, чадавхийг сайжруулах. 3.3 Зоонозын халдварын хүний өвчлөл бүртгэгдсэн болон өвчний дэгдэлт гарсан үед бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээг зохион байгуулах	ЭМЯ, ДЭМБ ХХААЯ НЭМҮТ, ХӨСҮТ, /МЭХ/ Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар
Ерөнхий чиг үүрэг-3: - Улсын хэмжээнд зоонозын төрөлжсөн мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагаа.		
ҮЧҮ-4: Улсын хэмжээнд зоонозын халдварын чиглэлээр сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ судалгааг хийж, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.	4.1 Харьяа ЗӨСТөвүүд, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагуудыг зоонозын халдварт өвчний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангах 4.2 Зоонозын халдварт өвчний чиглэлээр эрдэм шинжилгээ судалгаа хийх.	ЭМЯ, ДЭМБ ХХААЯ НЭМҮТ, ХӨСҮТ, /МЭХ/ Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар МЭЕГ, Экологийн хүрээлэн,
ҮЧҮ-5. Зоонозын өвчин судлалын үндэсний төв, зоонозын салбарын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.	5.1. Санхүү, хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, 5.2. Төвийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, 5.3. Эрх зүйн орчинг сайжруулах замаар ажилчдын нийгмийн баталгааг хангах, 5.4. Карьер хөгжлийн бодлого, залгамж халааг бэлтгэх тогтолцоог бий болгох. 5.5. Хамтын ажиллагааны төв сургалт, эрдэм, шинжилгээг хөгжүүлэх	ЭМЯ, ДЭМБ, Олон улсын байгууллага СЭЗЯ НЭ-ийн Төвүүд

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

“Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр номхон далайн баруун бүсийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хамтын ажиллагааны төв болно”

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

“Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан оновчтой зохион байгуулах замаар зоонозын өвчний эрсдэлийг бууруулах”

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 2 Орчний шинжилгээний нэгдсэн хүснэгт

ДОТООД ОРЧИН	
Давуу тал	Сул тал
1. Зоонозын халдварт өвчний эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх дадлага туршлагатай. 2. Зоонозын халдварт өвчний шинжилгээ, оношилогоо, судалгаа хийх Биоаюулгүйн II зэрэглэлийн лабораторитой. 4. Нянгийн тэжээлт орчин, будаг урвалж, оношлуур үйлдвэрлэн төвийн болон орон нутгийн төвүүдийн оношилгоо, судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг тасралтгүй хангадаг. 5. 15 аймагт зоонозын өвчин судлалын салбар төвүүдтэй 6. ОХУ, Казакстан, БНХАУ, ХБНГУ, Япон, Солонгос АНУ-ын мэргэжил нэгт байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээтэй, хамтын ажиллагааны хүрээнд төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг 7. Зоонозын халдварт өвчний чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны туршлагатай 8. Хоёр жил тутамд олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулдаг.	1. Төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар хууль эрх зүй, бодлогын баримтад тодорхой тусгагдаагүй, 2. Эрх зүйн баримт бичиг (стандарт, заавар, журам, удирдамж, гарын авлага, стандарт ажиллагааны заавар)-ийн нэр төрөл, шинэчлэл хангалтгүй, 3. Төвийн лаборатори нь олон улсын магадлан итгэмжлэлгүй, 4. Биоүйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй 5. Дархлаажуулалтын дараах дархлаа тогтоцын судалгааг бүрэн хийгдэдгүй, 6. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөөц хангалтгүй, 7. Эрдэм шинжилгээ судалгаа, тогтвортой хөгжүүлэх, хэрэгжүүлэх бодлого хангалтгүй, 8. Төвийн үйл ажиллагааг цахимжуулах, цахим шилжилт хийх нэгдсэн бодлого, тогтолцоогүй, 9. Зоонозын өвчин судлал үндсэн мэргэшил, мэргэшүүлэх сургалтын хүрээ хязгаарлагдмал, 10. Зоонозын өвчний эрсдэлтэй орчинд тандалт, хяналт хийх, халдварын голомтонд ажиллах томилолтын зардал хэт бага, 11. Олон улсын байгууллага, ДЭМБ болон НҮБ-ийн төрөлжсөн байгууллагуудтай хамтын ажиллагаа хангалтгүй, 12. Төвд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнууд (Биологич, биотехнологич, мэдээлэл технологийн мэргэжилтэн)-ыг давтан сургалтанд хамруулах тогтолцоогүй, 13. Цалин, ажлын нөхцөл, карьер өсөх боломж, эмч ажилтны тогтвор суурьшилтай ажиллуулах, нөхөн хангалт хийх боломж муу 14. Зоонозын өвчний байгалийн голомтын төлөв байдал, эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг тогтоох суурь судалгаа хангалтгүй,
ГАДААД ОРЧИН	
Боломж	Эрсдэл

1. Хөрш орнуудын хувьд шинжлэх ухааны суурь хөгжил сайн, 2. Хил дагуух зоонозын өвчний хамтарсан судалгаа шинжилгээ хийдэг, 3. Гуравдагч орнуудтай зоонозын өвчний чиглэлээр хамтарсан судалгаа, шинжилгээг өргөжүүлэх боломжтой, 4. Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, 5. Төвийн хүний нөөцийг чадавхжуулах, туршлага судлах, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авдаг.	1. Зоонозын зонхилон тохиолдох халдварт өвчнөөс гадна зөөвөрлөгдөх эрсдэлтэй, анзаарагдадгүй судлах шаардлагатай халдварт өвчний тоо нэмэгдэх хандлагатай, 2. Дэлхийн дулаарал, байгаль цаг уурын өөрчлөлтөнд нутагшмал, болон шинэ зоонозын халдварт өвчин сэргэн тархах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй, 3. Хамтарсан тандалт судалгаагаар цуглуулсан дээж, сорьцод хийсэн судалгааны мэдээ мэдээллийн хамгаалалт сул, хяналтгүй, 4. Бодлого боловсруулагч шийдвэр гаргагч нарын Зоонозын салбарын талаар мэдээлэл, ойлголт дутмаг, 5. Үндэсний уламжлалт зан үйл зоонозын халдварт өвчин буурахгүй байх нөхцөл болдог.
--	---

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

“Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг эмч мэрэгжилтнүүдийн туршлага, чадавхид үндэслэн, судалгаа, шинжилгээ, нотолгоонд тулгуурлан, оновчтой бүтэц, эрх зүйн орчин бүрдүүлэн халдварын эрсдэлийг бууруулах замаар хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх”

ДОЛОО: СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Хэрэгжүүлэх арга зам / Стратеги/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг: <i>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох.</i>					
Үндсэн чиг үүргийн нэр: <i>Монгол Улсын хэмжээнд Зоонозын халдварт өвчнийг тандах, судлах, хянах,</i>					
1.Төвийн хууль эрх зүйн орчнийг боловсронгуй болгох	1.1. ЗӨСҮТ, ЗӨСТ –ийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд тусгах	Боловсруулсан саналын тоо, чиглэл	Эрх зүйн зохицуулалт хангалтгүй	Зоонозын салбарын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах заалтууд орсон хууль батлагдаж, эрх зүйн орчин бэхжсэн байна.	Улсын төсөв
	1.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	2 аймагт ЗӨСТ, 1 хилийн нэвтрэх цэгт тандалтын нэгж	14 аймагт салбар төвтэй	2 аймагт ЗӨСТ, 1 хилийн нэвтрэх цэгт тандалтын нэгж байгуулагдсан байна.	Улсын төсөв
2. “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал, үйл ажиллагааг эрчимжүүлэх	9.3. Нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан үндэсний түвшинд хангах салбар хоорондын зохицуулалт, тандалт, судалгаа, хариу арга арга хэмжээний хамтарсан баг байгуулах,	- Хамтарсан баг байгуулагдсан байх	Хамтарсан тушаалын хүрээнд судалгаа, шинжилгээ дэгдэлтийн үед тогтмол хамтран ажиллаж байна.	Салбар хоорондын мэргэжлийн багууд дэгдэлтийн өмнөх болон дэгдэлтийн үеийн судалгаа, шинжилгээг хамтран зохион байгуулж, нэгдсэн удирдамж, мэргэжил арга зүйгээр улсын хэмжээнд хариу арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв Төсөл, хөтөлбөр

	2.2 Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчнүүдийг тодорхойлон тухайн халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний стратеги боловсруулан хэрэгжүүлэх	Тэргүүлэх чиглэлийн 3-5 халдварыг тогтоон стратеги боловсруулсан байх	Мал эмнэлэг, экологи, орчны шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладаг.	Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчний тархалтыг бууруулах цогц арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв Орон нутгийн төсөв Бусад төсөл хөтөлбөрүүд-тэй уялдуулах
2. Зоонозын өвчний хүн амын дундах тархалтыг тогтоох тандалт, судалгаа хийх, эрсдлийн түвшинг тогтоох, үйл ажиллагааг цахимжуулах	2.1. Зоонозын халдварт өвчний бүртгэл мэдээллийн тогтолцоог шинэчлэх	ZIS программыг 100 хувь нэвтрүүлсэн байна	Төвийн хэмжээнд ZIS програмыг хэрэглэж байгаа хэдий ч нэвтрүүлэлт программ хөгжүүлэлт хангалтгүй байна.	Орон нутгийн ЗӨСТ-үүдэд ZIS программ нэвтэрсэн байна. ЗӨСТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийг сургасан байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт
	2.1. Хүн амын дунд анзаарагддаггүй зарим зоонозын халдварт өвчний тандалтыг өргөжүүлэх, эрт илрүүлэх, тархалтыг тогтоох	Илрүүлэлт, Тандалт, судалгааны тоо	Бэтэг болон хачгаар дамжих зарим зоонозын халдварт өвчний тандалт, судалгаа хийгдэж эхэлсэн.	Хүн амын дунд анзаарагддаггүй зарим өвчнүүдийн илрүүлэг нэмэгдэнэ.	Улсын төсөв
	2.2.1. Нийслэлийн болон зарим аймгуудын эмнэлэг, лабораторитай хамтран халдварын тархалт, эрсдэлт бүлгийн хүн амын дундах эрсдэлт хүчин зүйл, зан үйлийг тандан судлах	Тандалт судалгааны тайлан	Хүний өвчлөлийн тохиолдол бүртгээгүй Жирэмсэн эхчүүдэд хийсэн TORCH шинжилгээний 1%-д Ig M, 10%-д Ig G илэрсэн дүн бий.	Зоонозын халдварын тархалт, эрсдэлт бүлгийн хүн амын дундах эрсдэлт хүчин зүйл, зан үйлийг тогтоосон байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт
	2.2.2. Хачгаар дамжих зоонозын өвчний тархалтыг хүн амын дунд бүсчилсэн хэлбэрээр илрүүлэг судалгааг хийж гүйцэтгэх	- Хамрагдсан аймаг бүрийн судалгааны тайлан	Хачгаар дамжих бусад халдварын хүний өвчлөлийг бүртгээгүй Хачгаар дамжих халдварын 50% орчим хувь нь /ХЭ, ХБ, ХР/ онош батлагддаггүй.	Хачгаар дамжих бусад халдварын тархалтыг хүн амын дунд бүсчилэн тогтооно. Цаашдын судалгааны чиглэл гарна.	Дэлхийн банк

	2.2.3. Мэргэжлээс шалтгаалах зоонозын халдварт өвчний эрсдэлд суурилсан судалгааг үндэсний түвшинд хийж гүйцэтгэх	-Судалгааны тайлан	Малын эмч нар зоонозын өвчлөлд өртөх эрсдэл ихтэй ч хийгдсэн судалгаа байхгүй.	Малын эмч нарын дунд тохоплазмоз, криптоспироз листери, шүлхий, ям зэрэг өвчний халдварлалтыг тогтооно.	Улсын төсөв Гадны санхүүжилт
	2.3. Булган, Сэлэнгэ, Говь-Алтай аймагт хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиозоор батлагдсан хүмүүсийн дунд эмнэл зүйн үлдэцийн судалгаа хийх	-Судалгааны тайлан	2020 онд Сэлэнгэ аймагт хийсэн судалгаагаар эдгэсэн /ХЭ,ХБ/ 34 хүний 50 орчим хувь эмнэл зүйн үлдэцтэй байсан. ХР-оор эдгэрсэн хүмүүсд эмнэл зүйн үлдэцийн судалгаа хийгдээгүй.	Эмнэл зүйн үлдэцтэй иргэдийн хувь тогтоогдоно.	Дэлхийн банк Дэмжих сан
3. Зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжлийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх	3.1. Зоонозын халдварт өвчний байгалийн голомтын мэдээллийг цахимжуулах	Цахимжуулсан анхан шатны бүртгэл, маягтын тоо	Мэргэжилтнүүд зохих хэмжээнд сургагдсан хэдий ч Цахим мэдээллийн программд анхан шатны маягтууд бүрэн ороогүй	Зоонозын халдварт өвчний байгалийн голомтын программ шинэчлэгдэж, төвийн хэмжээнд нэвтэрсэн байна.	Улсын төсөв Гадаад болон дотоодын төсөл хөтөлбөр байна.
	3.2. Зонхилон тохиолдох нутагшмал зоонозын халдваруудын байгалийн голомтын тархалтыг тандах, хянах	Голомтын тоо Тандалтын гүйцэтгэлийн хувь	Тарваган тахал, боом, галзуу, хачигт энцефалит, боррелиоз, риккетсиоз өвчний идэвхжлийн төлөв байдал, тархалт, хил хязгаарыг жил бүр шинэчлэн тогтоодог.	Зонхилон тохиолдох нутагшмал зоонозын халдваруудын байгалийн голомтын тархалтад хяналт тавьж, хөдлөл зүй, төлөв байдлыг тогтоосон байх	Улсын төсөв
	3.3. Анзаарагддаггүй буюу судлах шаардлагатай зоонозын халдварууд шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт,	Илрүүлсэн шинэ голомтын тоо Голомтын зураглал	Монгол оронд байгалийн голомт тэмдэглэгдсэн бэтэг, шувууны томуу, баруун нилийн	Эдийн засгийн бүсчлийн дагуу баруун, төв, зүүн бүс дахь аймгуудад байгалийн бүс,	Улсын төсөв Гадны санхүүжилт

	байгаль орчны хүчин зүйлтэй уялдуулан судлах		халуурал, хулгана тахал, лептосипириоз, ям, листериоз, эризеплойд, пастерлиоз, Ку халуурал, анаплазмоз, токсоплазмоз, криптоспридиоз, Япон энцефалит, ханта вирусын зэрэг өвчний байгалийн голомтын тархалт бүрэн тогтоогдоогүй байна.	бүслүүр бүрийг хамруулан шинэ сэргэн тархаж буй өвчний халдваржилт илрүүлэх хайгуул шинжилгээ хийгдсэн байна.	
	3.4. Тарваган тахал өвчний байгалийн голомтод эпизоотын идэвхжлийг бууруулах ажлыг бүсчлэн зохион байгуулах	Ажлын тайлангийн тоо	Зарим аймгуудад тарваган тахлын байгалийн голомт эпизооти өндөр идэвхитэй байгаа нь тогтоогдсон.	Эрсдэлийг бууруулсан голомтын тоо нэмэгдэж, ард иргэдийг халдварт өртөхөөс сэргийлсэн байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт
4. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хөгжүүлэн, чадавхийг бэхжүүлэх	4.1. Лабораторийн үйл ажиллагаанд ISO15189 стандартыг нэвтрүүлж, итгэмжлэгдэх	Магадлан итгэмжлэл	Бэлтгэл ажил 78 хувьтай	Магадлан итгэмжлэлд хамрагдсан байна.	Улсын төсөв
	4.2. Зоонозын өвчний оношилгоо, судалгаанд үүсгэгчийн генийн дараалал тогтоох молекул биологийн шинжилгээг үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Молекул биологийн шинжилгээний тоо	ЗХӨ-ний үүсгэгчдийн амьд омгийн цуглуулгын сантай.	Тарваган тахал, боом өвчний нуклеотидын дараалал тогтоох геномын анализ хийх, мэргэжилтэн сургагдаж бэлтгэгдсэн байна.	Улсын төсөв
	4.3. ЗӨСТ-үүдийн молекул биологийн лабораторийг үе шаттайгаар байгуулах шинжилгээний чадавхийг сайжруулах	Молекул биологийн шинжилгээ хийдэг ЗӨСТ-ийн тоо	Орон нутгийн ЗӨСТ-ийн лабораторийн хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн чадавхи тодорхой	ЗӨСТ-ийн лабораториуд ЗХӨ-ний молекул биологийн оношлогоог хийдэг болсон байна.	Улсын төсөв

			хэмжээнд бүрдэж байгаа.		
	4.4. ЗӨСТ-ийг Молекул биологийн шинжилгээ, оношилгооны хүний нөөцийн үндэсний түвшинд бэлтгэн хангаж, чадавхижуулах	Сургагдсан мэргэжилтний хүний тоо.	Хүний нөөцийн чадавхи тодорхой хэмжээнд бүрдсэн.	ЗӨСТ-үүд Молекул биологийн шинжилгээ, оношилгоо хийх чадавхи бүрдсэн байна.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр-н санхүүжилт
	4.5. Зоонозын өвчний оношилгоо, судалгаанд эс өсгөвөрлөх аргыг туршин нэвтрүүлэх	Туршилт судалгааны тайлан	Хүний нөөцийн чадавхи тодорхой хэмжээнд бүрдсэн.	ЗӨСТ-үүд эс өсгөвөрлөх шинжилгээ, оношилгоо хийх чадавхи бүрдсэн, үр дүн гарсан байна.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр-н санхүүжилт
	4.6. Биоаюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лабораторийг хэсэгчлэн байгуулж, чадавхийг бэхжүүлэх	Биоаюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лабораторитой болсон байх	Хүний нөөцийн чадавхи, барилга шинэчлэл, засварын ажил, тоног төхөөрөмжийн судалгаа хийгдэж байна.	Биоаюулгүй ажиллагааны III зэрэглэлийн лаборатори хэсэгчлэн байгуулагдсан байна.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр-н санхүүжилт
	4.7. Зоонозын халдварт өвчний үүсгэгчийн генийн дараалал тогтоох фрагмент анализын судалгаа хийх	Судалгааны Тайлан,	Мэргэжилтэнүүд фрагмент анализын арга зүйн анхан шатны мэдлэг эзэмшсэн. ЗХӨ-ний үүсгэгчдийн амьд омгийн цуглуулгын сантай.	Зоонозын өвчин үүсгэгчийн генотип, полиморфизмын судалгаа хийгдсэн, үр дүн гарсан байна.	Улсын төсөв, судалгааны төсөлт ажил
	4.8. Зоонозын лабораторийн био аюулгүй байдлыг үе шаттайгаар сайжруулах	Лабораторийн Био аюулгүй байдлын нөхцөлийн үнэлгээний тайлан,	Био аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийгдэж байна.	Лабораторийн био аюулгүй байдал сайжирсан байна.	Улсын төсөв, судалгааны төсөлт ажил
5. Зоонозын өвчин үүсгэгч бичил биетэн оношлох, оношлуурын Биобэлдмэлийн	5.1.“Микробиологийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэлийн үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл” авч монгол улсад үйл ажиллагаа явуулаж буй лабораторуудыг	Биобэлдмэлийн үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл” авсан	ЗӨСҮТөвийн ерөнхий захирлын 2020 оны 02 сарын 14-ний өдрийн А/11 ажлын хэсэгийг зохион	Микробиологийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэлийн үйлдвэрлэл явуулах	Улсын төсөв,

үйлдвэрлэлийг эрчимжүүлэх,	оношилгооны тэжээлт орчин, будаг урвалж уусмалаар хангах.		байгуулан ажиллах, төлөвлөсөн ажлыг хийж гүйцэтгэж . Тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг хангах бэлтгэл ажил 75%-тай хийгдсэн.	зөвшөөрлөө авсан байна. MNS:5524-1:2014, MNS:5524-2:2014 Монгол улсын аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлийн тухай хууль	
	5.2. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл авах	Химийн хорт болон аюултай бодис тусгай зөвшөөрөл авсан	ЗӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2015 оны 10 сарын 30-ны өдрийн А/62 тоот тушаалын 2-р хавсралт “Химийн лабораторит ажиллах аюулгүй ажиллагааны заавар”, 3-р хавсралт “Тэжээлт орчин будаг урвалжийн ангилал” Төвийн захирлын 2016 оны 11-р сарын 17-ны өдрийн А/74 тоот тушаал “Химийн шинжилгээний арга зүй	Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл авсан байна	Улсын төсөв,
	5.3 Зоонозын өвчний шинжилгээ, судалгаанд хуурайшуулсан тэжээлт орчинг туршин нэвтрүүлэх	Туршилтын тайлан	Хүний нөөцийн чадавхи тодорхой хэмжээнд бүрдсэн.	Тэжээлт орчин хуурайшуулах горимыг тогтоож, нян өсгөвөрлөх шинжилгээ, судалгаанд ашиглаж үр дүн гарсан байна.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр-н санхүүжилт

	5.4. Зоонозын өвчний оношилгоо, судалгаанд улаан эст оношлуурыг туршин нэвтрүүлэх	Туршилтын тайлан,	Хүний нөөцийн чадавхи тодорхой хэмжээнд бүрдсэн.	Улаан эст оношлуурыг гарган авч шинжилгээ, оношилгоо хийх чадавхи бүрдсэн, үр дүн гарсан байна.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр-н санхүүжилт
Үндсэн чиг үүрэг: Үндэсний хэмжээнд зоонозын өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих					
6. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинэлэг хэлбэрээр үзүүлэх замаар иргэдийн уламжлалт зан үйлийг өөрчлөх, мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулах,	6.1.Мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт зан үйлийг бууруулах зорилготой мэдээлэл бүхий орчин үеийн технологит суурилсан мэдээллийг боловсруулж түгээх	- Боловсруулж түгээсэн мэдээллийн тоо	Мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт зан үйлийг бууруулах үйл ажиллагааг боломжит мэдээллийн сувгуудаар дамжуулан хүргүүлж байна.	Зоонозын халдварт өвчний мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт зан үйлийг бууруулах зорилготой мэдээлэл бүхий орчин үеийн технологит суурилсан мэдээллийг боловсруулж түгээснээр иргэд олон нийт мэдээллээр хангагдсан байна.	Улсын төсөв,
	6.2.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, иргэдийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	- Батлуулсан хөтөлбөр Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт зан үйлийг бууруулах үйл ажиллагааг тухайн цаг хугацаанд төлөвлөн удирдамж боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, иргэдийн зан үйлд нөлөөлөх тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлснээр ЗХӨ-ний нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.	Улсын төсөв,
	6.3. Зоонозын халдварт өвчний үеийн эрсдэлийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг сайжруулах	- Эрсдэлийн мэдээлэл харилцааг сайжруулах хүрээнд гаргасан бодлого чиглэл	Зоонозын халдварт өвчний эрсдэлийн мэдээлэл харилцааг иргэд олон нийт, эмнэлгийн байгууллагуудад,	Зоонозын халдварт өвчний үеийн эрсдэлийн мэдээлэл харилцааны үйл ажиллагааг сайжруулснаар иргэд	Улсын төсөв,

		Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	бусад салбар хоорондын байгууллагуудад чиглэсэн хэлбэрээр үйл явдал, өвчлөл, дэгдэдлт бүртгэгдсэн тохиолдол бүрт тусгайлсан мэдээлэл боловсруулан хүргүүлэн ажиллаж байна.	олон нийт болон бусад байгууллага мэргэжилтнүүд мэдээллээр тогтмол шуурхай хангагдах боломж бүрдэнэ.	
7. Хүн амын дунд зоонозын өвчнөөс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн ажлыг зохион байгуулах:	7.1 Өвөрмөц урьдчилан сэргийлэх хяналтад цахим технологи нэвтрүүлэх		Өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн төлөвлөлт цахимжсан	Өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн хяналт цахимжсан байна	Улсын төсөв Гадны санхүүжилт
	7.2 Эрсдэлт бүлгийн хүн амд зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтыг оновчтой зохион байгуулах	Дархлаажуулалтын хамралтын түвшин	Жил бүр зохион байгуулан хийгддэг	Дархлаажуулалтын хамралт өндөр түвшинд хадгалагдана.	Улсын төсөв Гадны санхүүжилт
	7.3 Зарим зоонозын өвчний вакцины дархлаа тогтоц болон эдийн засгийн үр ашгийн судалгаа хийх	- Удирдамж Судалгааны үр дүн	Судалгаа тогтмол хийгдээгүй.	Өвчлөл тус бүрээр вакцины үр ашгийн судалгаа хийгдэж, цаашдын чиглэл тодорхойлогдсон байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт
Ерөнхий чиг үүрэг 2: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах үйл ажиллагаа.					
Үндсэн чиг үүрэг: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах					
8. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн бэлэн байдлыг хангах	8.1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн агуулах ашиглалтанд оруулж, үйл үйл ажиллагааг тогтмолжуулах	Нөөцийн агуулахын байр Ашиглалт Нөхөн хангалт	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн агуулахын барилгын явц 90%	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн агуулах ашиглалтанд оруулж, үйл үйл ажиллагаа тогтмолжсон байна.	Гадны санхүүжилт

9. Зоонозын өвчний аюул, эрсдлийн үед авах хариу арга хэмжээний багийн бэлэн байдал, чадавхийг сайжруулах.	9.1. Зоонозын өвчний аюул, эрсдэлийн үед авах хариу арга хэмжээний багийн бэлэн байдал, чадавхийг сайжруулах.	Бэлэн байдлын чадавхи Сургалтад хамрагдсан тоо	Дуудлагын багуудын хүний нөөц хангалттай	Зоонозын өвчний аюул, эрсдэлийн үед авах хариу арга хэмжээний багийн бэлэн байдал, чадавхи сайжирсан байна.	Улсын төсөв
	9.2. Тохиолдлын удирдлагын тогтолцооны зарчимд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн удирдлагын менежментийг сайжруулах	ТУТ-ны тушаал Удирдлагын менежментийг нэвсрүүлсэн байдал	ТУТ-ны тушаалаар бүх халдварын дэгдэлт, цар тахлын үед ажиллаж байна.	Бэлэн байдал, хариу арга хэмжээг удирдан чиглүүлэх шийдвэрийг цаг алдалгүй, нотолгоонд тулгуурлан гаргадаг болсон байна.	Улсын төсөв
	9.3.Салбар хоорондын зохицуулалт, харилцаа холбоо, мэдээлэл солилцооны механизмын үйл ажиллагааг Нэг эрүүл мэнд үзэл баримтлалд тулгуурлан үндэсний түвшинд хангах	- Хамтран ажиллах эрх зүй - Солилцсон мэдээллийн тоо Хамтын гэрээ	Хамтарсан тушаалын хүрээнд судалгаа, шинжилгээ дэгдэлтийн үед тогтмол хамтран ажиллаж байна.	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн тогтвортой үйл ажиллагаа хангагдсан байна.	Улсын төсөв
10. Зоонозын халдварын хүний өвчлөл бүртгэгдсэн болон өвчний дэгдэлт гарсан үед бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээг зохион байгуулах	10.1. Коронавируст халдвар (Ковид 19) цар тахлын нөхцөл байдал, шинэ мутац хувилбартай уялдуулан хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах	Төлөвлөгөө Шинжилсэн сорьцын тоо Сургалт явуулсан тоо		Коронавируст халдвар (Ковид 19) цар тахлын нөхцөл байдал, шинэ мутац хувилбартай уялдуулан хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулна.	Улсын төсөв
	10.2.Зоонозын өвчлөл бүртгэгдсэн болон өвчний дэгдэлт гарсан үед бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний судалгаа тайлан Эрсдлийн үнэлгээ Хамтарсан хариу арга хэмжээний тайлан	Зоонозын өвчлөл бүртгэгдсэн болон өвчний дэгдэлт гарсан үед бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээг үндэсний түвшинд шуурхай зохион	Зоонозын өвчний тандалт, хянах, сэргийлэх арга хэмжээг олон салбарын оролцоонд тулгуурлан зохион байгуулснаар зоонозын өвчний эрсдэлийг бууруулна.	Улсын төсөв

			байгуулан ажиллаж байна.		
	10.3 Зоонозын халдварт өвчний тандалтын тогтолцоонд тойм үнэлгээ хийх	- Батлагдсан төлөвлөгөө - Судалгааны удирдамж Үнэлгээний тайлан	Олон эх суравалжит тандалтын тогтолцоог нэвтрүүлэн ашиглаж байна.	Тойм үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд суурилсан тандалтын тогтолцооны бодлого боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Улсын төсөв
Ерөнхий чиг үүрэг 3: Улсын хэмжээнд зоонозын төрөлжсөн мэргэшилээр лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх бөгөөд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.					
Үндсэн чиг үүрэг: Улсын хэмжээнд зоонозын халдварын чиглэлээр сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ судалгааг хийж, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах					
11. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх	11.1 Олон улсын хамтарсан төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх	Хамтарсан төсөл хөтөлбөрийн тоо	2021 онд АНУ-тай хамтарсан 1 судалгааны төсөл, ОХУ-тай хамтарсан хамтарсан 1 хөтөлбөр хэрэгжиж байна.	Гадаадын улс, байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоо, хүртээмж нэмэгдсэн байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт
12. Харьяа ЗӨСТөвүүд, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагуудыг зоонозын халдварт өвчний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	11.2 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын сургалтын төвийг байгуулж, тасралтгүй сургалтын тогтолцоог бэхжүүлэх	Сургалтанд хамрагдсан хүний тоо	Хамтын ажиллагааны хүрээнд болон ЭМЯ-ны дэмжлэгээр сүүлийн 5 жилд урт богино хугацааны сургалтад 25 эмч, мэргэжилтэн сургагдсан.	Орчин үеийн шинэ технологи, арга зүй эзэмших чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах мэргэжилтний тоог нэмэгдүүлсэн байна.	Улсын төсөв, гадаад хамтын ажиллагаа ЭМДСан
	11.3 Төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх таатай нөхцөл бүрдүүлэх	- Урамшуулал дэмжлэг үзүүлэх, эрх зүйн акт, - Судалгааны лаборатори,	Залуу судлаачдыг дэмжих зорилгоор судлаачид болон судалгааны багуудыг урамшуулдаг тогтолцоо бүрдсэн.	Судалгаа шинжилгээний ажил хийх эрх зүйн болон лабораторийн таатай орчинг бүрдсэн байна.	Улсын төсөв Гадны санхүүжилт


	11.4 Зоонозын өвчин судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр шинчлэх	Шинэчлэгдсэн хөтөлбөр, тушаал шийдвэр	Эмнэлзүйн батлагдсан хөтөлбөртэй. 4 жил сургалт явуулсан туршилтаар	Эмнэлзүйн бус хөтөлбөр батлуулах	Улсын төсөв, ЭМДСан
	11.5 Зоонозын өвчин судлалын сургалтын хүрээ, хамрагдалтыг нэмэгдүүлэх. ЗӨСТ-гүй аймгуудад мэргэжилтэн бэлтгэх	Суралцсан мэргэжилтний тоо	4 жилийн хугацаанд 30 мэргэжилтэн бэлтгэсэн	Стратегийн хугацаанд 20 мэргэжилтэн нэмж бэлтгэх	Улсын төсөв, ЭМДСан
Ерөнхий чиг үүргийн нэр-4: Зоонозын өвчин судлалын үндэсний төв, зоонозын салбарын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.					
Үндсэн чиг үүргийн нэр: Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, засаглал, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах					
13. Санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	13.1 Хүн амын болон байгалийн голомтын тандалт судалгааны ажлын өртөгийг тодорхойлж төсвийн төсөлд тусгах замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,	Тандалт судалгаа шинжилгээ хийгдэж, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.	Тандалт, судалгаа, шинжилгээ, оношилгооны ажил хийгдэх боломж бүрдсэн байна.	Санхүүжилт, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байх	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр-н санхүүжилт
	13.2 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг үе шаттай нэвтрүүлэх	Нийгмийн эрүүл мэндийн болон гамшиг онцгой байдлын санхүүжилт батлагдсан байна.	Үйл ажиллагаа тасралтгүй хэвийн хэрэгжсэн.	Зардлыг санхүүжүүлэх	Улсын төсөв
	13.3 Эрүүл мэндийн үндэсний тооцоо, төсвийн төсөл боловсруулахад ашиглах тусламж үйлчилгээний өртөг тооцох	Өртөг тооцсон байна	Өртөгийн тооцоолол хийгдээгүй		Улсын төсөв
14. Төвийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	14.1 Төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд үндэслэн төвийн бүтэц, зохион байгуулалт, шаардагдах хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж төлөвлөлтийг боловсронгуй болгох	Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Төвийн дүрэм, дотоод журам шинэчлэгдэн батлагдсан байна	2017-2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хугацаа дууссан	Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчинг сайжруулсан байна.	Улсын төсөв, ЭМДСан
	14.2 Системийн тайлан мэдээ, тоо баримтыг нэгдсэн загварт оруулах, анхан шатны бүртгэлийг шинчлэх	Батласан тушаал шийдвэр,	Системийн хэмжээнд хөтлөгдөж байгаа 100 гаруй анхан шатны бүртгэл байгаагаас шинжлэх	Системийн хэмжээний тайлан мэдээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	Улсын төсөв, ЭМДСан

			шаардлагатай 30 орчим бүртгэл байна.		
	14.3 Системийн шинжилгээ хийх замаар төвийн үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг цахимжуулах ажлыг эхлүүлэх.	Системийн шинжилгээний тайлан.	Системийн шинжилгээ хийгдэж байгаагүй	Системийн шинжилгээний тайланд үндэслэн төвийн үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг цахимжуулах бодлогын даалгаврууд гарсан, тодорхой хэмжээнд хэрэгжиж эхэлсэн байна.	Улсын төсөв, Олон улсын санхүүжилт
	14.4 Зоонозын өвчний тусламж үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн чанар сайжруулах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах.	Чанар, аюулгүй байдлыг сайжруулах шинэчилсэн төлөвлөгөө.	Төвийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийг бууруулах 7 зорилтын 25 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Төвийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг эрс сайжруулах, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, график гарган баталж, хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсөв
Үндсэн чиг үүргийн нэр: Зоонозын салбарын эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг сайжруулж хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах.					
15. Эмч, ажилчдын нийгмийн баталгааг хангах, Карьер хөгжлийн бодлого, залгамж халааг бэлтгэх тогтолцоог бий болгох	15.1 Цалин урамшууллын оновчтой тогтолцоо, өвөрмөц шатлалыг нэвтрүүлэн, гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем бий болгох	Журам-1 Аргачлал-2 батлагдсан байна.	Үндсэн цалингийн шатлалд суурилсан салбарын дундаж цалин	Хууль, Тушаал нэмэлт өөрчлөлт, Журам аргачлал батлагдсан байна.	Улсын төсөв, ЭМДСан
	15.2 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн байх	2017-2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хугацаа дууссан	2022-2024 оны хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Улсын төсөв, ЭМДСан
	15.3 Эмнэл зүйн бус зоонозын мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан, батлуулах	Батлагдсан эмнэлзүйн бус мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр	Эмнэлзүйн хөтөлбөрөөр 30 эмч мэргэжлтэн суралцаж төгссөн.	Жил бүр 10-12 мэргэжилтэн сургаж төгсгөсөн байна. Нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийн 30%-ийг эмнэл зүйн бус хөтөлбөрөөр	Улсын төсөв, ЭМДСан


				үндсэн болон төрөлжсэн мэргэшлийн сургалтад хамруулсан байна	
15.4 Салбарын ажилтнуудыг дадлагажуулах, давтан сургах замаар залгамж халааг бэлтгэх	Дадлагажуулах сургалтанд хамрагдсан хүний тоо	Хөтөлбөрийн дагуу төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж байна.	Салбарын мэргэжлийн, чадвартай боловсон хүчний нөөц бэлтгэгдэж, залгамж халаа тасралтгүй хөгжнө. Жил бүрийн хөтөлбөр төлөвлөгөө батлагдан хэрэгждэг болно.	Улсын төсөв, ЭМДСан	
15.5 Албан тушаал дэвших, өөр албан тушаалд шилжин ажиллах нээлттэй, шударга өрсөлдөөнийг дэмжих замаар ажилтны карьер хөгжлийг дэмжих	Дүрэм журамд тусгагдсан байх	Ажилтан, албан хаагчидыг албан тушаал сэлгэх, дэвших боломжийг ханган ажиллаж байна.	Өрсөлдөөний нээлттэй, ил тод байх зарчмыг бүрэн хангаж, хүний нөөцийн чадавхи бэхжинэ	Улсын төсөв, ЭМДСан	
15.6 Мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа ажилтнуудыг дэмжин, хувь хүний манлайллыг хөгжүүлэх	Сэтгэл ханамжийн судалгааны дүн	Төвийн хэмжээнд Хувь хүний хөгжил, ёс зүй болон мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулан ажилласан.	Байгууллагад эерэг соёлыг бэхжүүлж, хувь хүний хөгжил, манлайллыг дэмжих замаар тогтвортой хүний нөөц бүрдүүлсэн байна.	Улсын төсөв, ЭМДСан	
15.7 Боловсролын зэрэгтэй мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлогоор дэмжих, төрүүлэн гаргах	Хамгаалсан Магистр доктор	Одоо байгаа боловсрлын зэрэгтэй мэргэжилтний тоо, хувь	Боловсролын зэрэгтэй мэргэжилтнүүдийн хувийг нэмэгдсэн байна /магистр, доктор/	Улсын төсөв, ЭМДСан	

**Найм. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж,
байгууллагын бүтцийн уялдаа, зураглал**

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН УЯЛДАА ХОЛБОО



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



Ес. Хавсралт

9.1 Мандатын шинжилгээ

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрэмд заасан үндсэн чиг үүрэг:

- 3.1. Улсын хэмжээнд зоонозын халдварт өвчнүүдийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 3.2. Чиг үүргийн хүрээнд хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх;
- 3.3. Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.4. Монгол Улсын хэмжээнд зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжлийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх;
- 3.5. Зоонозын өвчний дэгдэлтийн үед голомтод эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
- 3.6. Чиг үүргийн хүрээнд орон нутгийн харьяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- 3.7. Чиг үүргийн хүрээнд лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, улсын хэмжээнд зоонозын халдварт өвчний мэдээллийн сан бүрдүүлэх.

2. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

1.1.2.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

1.1.3.2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна.

1.1.3.4. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулна.

3. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн а/456 дугаар тушаал,

3.3. ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ:

3.3.1. Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон хэрэгжүүлэх, мэргэжлийн анги, тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхижүүлэх;

- 3.3.2. Коронавируст халдвар /ковид-19/-ын үед суурин болон явуулын вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийх;
- 3.3.3. Коронавируст халдвар /ковид-19/-ын хүн амын дундах өргөжүүлсэн тандалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийх;
- 3.3.4. Коронавируст халдвар /ковид-19/-аас урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх талаар тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах, зохицуулалт хийх;
- 3.3.5. Коронавируст халдвар /ковид-19/-ын голомтод шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулах;
- 3.3.6. Коронавируст халдвар /ковид-19/-ын халдварын дайчлагдан ажиллах хүний нөөцийг чадавхжуулах;
- 3.3.7. Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх биоаюулгүй ажиллагаа, халдваргүйжүүлэлтийн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;
- 3.3.8. Төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудад коронавируст халдвар /ковид-19/-ын голомтын болон эцсийн халдваргүйжүүлэлтийн давтан болон дадлагажуулах сургалт хийх;
- 3.3.9. Мал эмнэлгийн болон холбогдох байгууллагатай хамтран коронавируст халдвар /ковид-19/-ын судалгааг мал, амьтдын дунд улирал тутам тандан судлах;
- 3.3.10. Ариутгал, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн судалгааг гарган, холбогдох байгууллагад хүргүүлэх;
- 3.3.11. Коронавируст халдвар /ковид-19/-ын үед хийгдэх халдваргүйжүүлэлтийн талаар эрүүл мэндийн болон салбар хоорондын байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, цаашдын стратеги боловсруулах;
- 3.3.12. Коронавируст халдвар /ковид-19/-ын талаар иргэдэд мэдээлэл өгөх 70284393 утсыг 7/24 цагаар ажиллуулж, иргэдээс ирүүлж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийн, ташаа мэдээллийг тухай бүр залруулах.

Товчилсон үгийн жагсаалт

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
БХЯ	Батлан хамгаалах яам
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗӨСҮТ	Зоонозын өвчин судлалын үндэсний төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
МЭҮГ	Мал эмнэлэг, үржлийн газар
МЭХ	Мал эмнэлгийн хүрээлэн

НДББ	Номхон далайн баруун бүс
НҮБ-ын ХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУАЭА	Олон улсын атомын энергийн агентлаг
ОУЭМД	Олон улсын эрүүл мэндийн дүрэм
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТТССХ	Талбарын тархвар судлалын хөтөлбөр
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УМЭАЦТЛ	Улсын <i>мал</i> эмнэлэг, ариун цэврийн төв лаборатор
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХХ	Хувийн хамгаалах хэрэгсэл
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЦЭК	Цөмийн энергийн комисс
ШУН	Шуурхай удирдлагын нэгж
ШУТ	Шуурхай удирдлагын төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
APSED III	Сэргэн тархаж буй халдвар, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалтай тэмцэх Ази, Номхон далайн стратеги
GOARN	Өвчний дэгдэлтийг сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний дэлхийн сүлжээ
НАССР	Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянах тогтолцоо